



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 26 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Г Ур чадварын нэмэгдэл олгох,  
дүгнэх журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол, газрын хөдөлмөрийн дотоод журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Нийтлэг үйлчилгээний газрын нийт ажилтан, албан хаагчдад “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, ажлын үр дүн, ур чадварыг үнэлж дүгнэх журамыг 2-р хавсралтаар тус тус баталсугай.
2. Ур чадварын нэмэгдэл олгох тухай журмыг хэрэгжүүлж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад, дүгнэх журам, үзүүлэлтийг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт хариуцсан ажилтан /Ч.Шинэчимэг/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү журам гарсантай холбогдуулан газрын даргын 2015 оны А/54 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮРӨРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ ХЭРДЭНЭБИЛЭГ



1150522033

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын  
даргын 2018 оны 03 дугаар сарын 26-ны  
өдрийн 117 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

УХДФ153 2826046

**АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ  
“УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ” ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмжийг үнэлж “Ур чадварын нэмэгдэл” олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Ажилтан, албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэн ур чадварын нэмэгдэл олгох гэдэг нь тухайн ажилтан, албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүрэг, ажлын идэвхи санаачлага, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлж байгааг үнэлж урамшуулахад чиглэгдэнэ.
- 1.3 Ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг олгоходоо шударга ил тод зарчмыг баримтална.

**Хоёр. Ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох**

- 2.1 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтээ арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл шинийг санаачлан өдөр тутмын үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн ажилласан ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно.
- 2.2 Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, албан тушаалын цалингаас тооцож сар тутамд олгоно.
- 2.3 Ур чадварын нэмэгдлийн хэмжээг шууд удирдлаганд байгаа албан тушаалтаны санал, түүний өгсөн үнэлгээг харгалзан ажилтан, албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 10-25 хүртэл хувиар тооцон олгоно.
- 2.4 Ажилтан, албан хаагчдад ур чадвар олгох, дүгнэх асуудлыг газрын даргын тушаалаар баталсан ажлын хэсэг хариуцан гүйцэтгэнэ.
- 2.5 Ур чадварын нэмэгдлийг ажлын хэсгийн гишүүд болон хэлтэс, албадын дарга нар, менежерийн саналыг үндэслэн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж газрын даргын тушаалаар олгоно.
- 2.6 Захиргаа, санхүүгийн албан хаагчдыг хасас, бүтэн жилээр, үйлчилгээ, техникийн ажилтнуудыг улирал тутам үнэлж ур чадварыг дүгнэнэ.
- 2.7 Сахилгын шийтгэл авсан ажилтан, албан хаагчдад шийтгэлийн хугацаанд ур чадварын нэмэгдэл болон бусад шагнал, урамшуулалт олгохгүй.
- 2.8 Ур чадварын нэмэгдлийг олгоходоо ажилтан, албан хаагчийн тухайн улирал, хагас, бүтэн жилд бүрэн ажилласан эсэхийг тооцож дүгнэнэ.